

**СЭНДВИК МАЙНИНГ ЭНД РОК СОЛЮШИОНС
Стандарт Баталгаа**

(2024 оны 4-р сарын 15-с хойш зарагдсан Сэндвикийн Тоног Төхөөрөмж, Сэлбэг Хэрэгсэл, Чулуулгийн Багаж болон Хэрэглээний бүтээгдэхүүнд хамааралтай)

1. Тодорхойлолт:

- 1.1. **Ашиглалтад оруулах** гэж Хүргэлтийн дараа Сэндвикийн Тоног Төхөөрөмж нь Гэрээнд заасан техникийн үзүүлэлтүүдийн дагуу ажиллаж байгаа эсэхийг шалтган ашиглалтад оруулах гэрчилгээ эсхүл өөр бусад бичгээр мэдэгдэл гаргаж өгөх процессыг хэлнэ. Ашиглалтад оруулах процесс явагдаад дуусах боломж байсан боловч Худалдан Авагч Сэндвикийн ашиглалтад оруулах процессыг үндэслэлгүйгээр хойшлуулах эсхүл боломжийг үгүй болговол, Хүргэлтээс хойш нэг (1) сарын дараа Ашиглалтад оруулсан гэж тооцно.
- 1.2. **Гэрээ** гэж Сэндвик эсхүл Сэндвикийн Борлуулагч ба Худалдан авагч нарын хооронд байгуулсан Сэндвикийн Бараа нийлүүлэх бичгээр хийсэн гэрээг хэлнэ.
- 1.3. **Хүргэлт** гэж (i) ачааг илгээсэн өдөр, эсхүл (ii) Гэрээнд заасан харилцан тохиролцсон Инкотермсийн дагуу хүргэлт хийх өдрийг хэлнэ.
- 1.4. **ЖТТҮ (OEM - Original Equipment Manufacturer)** гэж Жинхэнэ Тоног Төхөөрөмж Үйлдвэрлэгчийг хэлнэ.
- 1.5. **Худалдан авагч** гэж Сэндвикийн Барааг Сэндвик болон/эсхүл Сэндвикийн Борлуулагчаас худалдан авч буй харилцагчийг хэлнэ. Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд мөн бичгээр харилцан тохиролцоогүй л бол Сэндвик эхний эцсийн хэрэглэгчээс цааш аливаа баталгаа өгөхгүй мөн ийнхүү баталгааг сунгахгүй.
- 1.6. **Сэндвик** гэж Сэндвик Группийн холбогдох хуулийн этгээдүүдийг хэлнэ.
- 1.7. **Сэндвик (БГЦМ) (BHEV - battery hybrid electric vehicle)** гэж Сэндвикийн батареин гибрид цахилгаан машиныг хэлнэ.
- 1.8. **Сэндвикийн Хэрэглээний бүтээгдэхүүн** гэж Гэрээний дагуу Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид шууд нийлүүлсэн эсхүл Сэндвикийн Борлуулагчаар дамжуулан Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид нийлүүлсэн дараах шинэ хэрэглээний бүтээгдэхүүнийг (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) хэлнэ; газартай харьцах багаж (үүнд *Shark*-н бүтээгдэхүүнд орно); нунтаглах аяга болон нунтаглах дугуй; мөн газар дээрх үйлчилгээнд хэрэглэх хэрэглээний бүтээгдэхүүн болон химийн бодис.
- 1.9. **Сэндвикийн Борлуулагч** гэж тодорхой нутаг дэвсгэрт Сэндвикийн Барааг сурталчлах, борлуулах зорилгоор Сэндвикийн борлуулагч гэж түүнийг төлөөлөхөөр гэрээгээр томилогдсон компанийг хэлнэ.
- 1.10. **Сэндвикийн Тоног төхөөрөмж** гэж Гэрээний дагуу Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид шууд нийлүүлсэн эсхүл Сэндвикийн Борлуулагчаар дамжуулан Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид нийлүүлсэн дараах шинэ тоног төхөөрөмжийг (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) хэлнэ; ачих болон зөөх машин; өрөмдлөгийн машин; газар доорх өдөөгч болон компрессор; механик огтлогч машин; газар дээрх үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж; мөн системүүд.
- 1.11. **Сэндвикийн Бараа** гэж Сэндвикийн Тоног Төхөөрөмж болон/эсхүл Сэндвикийн Сэлбэг Хэрэгсэл болон/эсхүл Сэндвикийн Чулуулгийн Багаж болон/эсхүл Сэндвикийн Хэрэглээний Бараа.
- 1.12. **Сэндвик Групп** гэж Сэндвик АВ-н хамаарал бүхий компаниуд.
- 1.13. **Сэндвикийн Чулуулгийн Багаж** гэж Гэрээний дагуу Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид шууд нийлүүлсэн эсхүл Сэндвикийн Борлуулагчаар дамжуулан Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид нийлүүлсэн шинэ чулуулгийн багаж, үүнд өрөмдлөгийн хэрэглээний бүтээгдэхүүн (бариулын адаптер; өрөмдлөгийн труба; өрмийн саваа; өрөмдлөгийн хоолой; өрөмдлөгийн бит (үзүүр); өргүүрт цооноглох багаж болон тоног төхөөрөмж; мөн доошоо нүхлэх алх (*DTH-down the hole*)); огтлох багаж болон чулуулгийн боолт; мөн нунтаглах машин.
- 1.14. **Сэндвикийн Сэлбэг Хэрэгсэл** гэж Гэрээний дагуу Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид шууд нийлүүлсэн эсхүл Сэндвикийн Борлуулагчаар дамжуулан Сэндвикийн эхний эцсийн хэрэглэгчид нийлүүлсэн (Сэндвикийн Хэрэглээний Бараанаас бусад) шинэ

сэлбэг хэрэгсэл, эд анги болон дижитал эсхүл холбогдсон үйлчилгээтэй холбоотойгоор нийлүүлсэн техник хангамжийг хэлнэ.

1.15. **Сэндвикийн Баталгаа** эсхүл **Баталгаа** гэж энэ баримтыг хэлнэ.

1.16. **Сэндвикийн Баталгааны Бүртгэлийн Маягт** гэж энэхүү Сэндвикийн Баталгааны 5-р заалтын дагуу өгсөн Сэндвикийн Тоног Төхөөрөмжийн бүртгэлийн баримтыг хэлнэ.

2. Баталгааны Хамрах хүрээ

Баталгаат хугацааны турш, энэхүү Баталгааны болзол, нөхцөлийн дагуу Сэндвикийн аливаа Бараа нь материал, хийцийн хувьд доголдолтой нь тогтоогдсон бол түүнийг засварлах, төлбөр буцаан олгох эсхүл солих (өөрийн сонголтоор) үүргээ Сэндвик Баталгааны 7-р заалтын дагуу биелүүлнэ гэж баталж байна.

3. Баталгаат Хугацаа

3.1. **Баталгаат хугацаа эхлэх.** Баталгаат хугацаа дараах байдлаар эхэлнэ:

3.1.1. Сэндвикийн Тоног Төхөөрөмжид: аль түрүүлж болсон өдрөөс, Ашиглалтад оруулсан өдөр эсхүл Сэндвик Баталгааны Бүртгэлийн Маягтад гарын үсэг зурсан өдөр; мөн

3.1.2. Сэндвикийн Сэлбэг Хэрэгсэл, Сэндвикийн Чулуулгийн Багаж, Сэндвикийн Хэрэглээний Бүтээгдэхүүн болон Сэндвикийн БГЦМ-н батареины модуль, Сэндвикийн БГЦМ-н батареины багц: Хүргэлтээс эхэлнэ.

3.2. **Баталгаат хугацаа дуусгавар болох.** Баталгаат хугацаа нь аль түрүүлж болсон өдөр дуусгавар болно, Худалдан Авагчид Хүргэлт хийснээс хойш арван найман (18) сар, эсхүл бүтээгдэхүүний төрөл бүрээр нь доор дурдсан өдрийн аль түрүүлж болсон өдрөөр:

3.2.1. Өрөмдлөгийн машин

3.2.1.1. Гадаргуу дээрх топ алх өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг, үүнд дараах ороогүй: агаарын төгсгөл: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; поршений насос болон мотор: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; болон гидравлик чулуулгийн өрөм: арван хоёр (12) сар эсхүл нэг мянган (1000) цохилтот цаг;

3.2.1.2. Газар доорх топ алх өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар;

3.2.1.3. Гидравлик чулуулгийн өрөм: арван хоёр (12) сар эсхүл нэг мянган (1000) цохилтот цаг;

3.2.1.4. Гадаргуун доошоо нүхлэх (*DTH-down the hole*) өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг, үүнд дараах ороогүй: агаарын төгсгөл: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; поршений насос болон мотор: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; болон эргэлтийн толгой: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг;

3.2.1.5. Доошоо нүхлэх (*DTH-down the hole*) алх (шинэ өрөмдлөгийн машинтай хамт зарагдаж байгаа тохиолдолд): гурван (3) сар;

3.2.1.6. Газар нүхэн дэх (*ITH-in the hole*) өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) гидравлик эрчим хүчний багц цаг, үүнд техник дахь харилцан өдөөгч ороогүй: нэг мянган (1000) ажлын цаг;

3.2.1.7. Эргэлтэт өрөмдлөгийн машин болон өндөр даралтат доошоо нүхлэх (*down-the-hole*) өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг, үүнд дараах ороогүй: агаарын төгсгөл: хорин дөрвөн (24) сар, цаг хязгааргүй; эргэлтийн толгой: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; поршений насос ба мотор: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; тэжээх болон домкрат цилиндр: арван хоёр (12) сар, цаг хязгааргүй; мөн

3.2.1.8. Өргүүрт цооноглох өрөмдлөгийн машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) ажлын цаг, үүнд дараах ороогүй: техник дахь харилцан өдөөгч: нэг мянган (1000) ажиллах цаг.

3.2.2. Ачих болон Зөөх

3.2.2.1. Ачигч болон ачааны машин: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) ажлын цаг;

3.2.2.2. Сэндвикийн БГЦМ батареи: арван хоёр (12) сар; мөн

3.2.2.3. Сэндвикийн БГЦМ батареи цэнэглэгч болон хөргөх нэгжүүд: арван хоёр (12) сар.

3.2.3. Механик Огтлогч

- 3.2.3.1. Тоног Төхөөрөмж: арван хоёр (12) сар эсхүл дөрвөн мянган (4000) гидравлик моторын цаг, үүнд дараах ороогүй: өрмийн толгой: зургаан (6) сар;
- 3.2.3.2. Резин дугуйтай тээврийн хэрэгсэл (RTV rubber-tired vehicle): арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг, мөн
- 3.2.3.3. Хурдан салгах системийн хэрэгсэл: зургаан (6) сар.
- 3.2.4. **Газар доорх Өдөөгч болон Компрессор**
- 3.2.4.1. Харилцан өдөөгч: арван хоёр (12) сар эсхүл нэг мянган (1000) ажлын цаг, мөн
- 3.2.4.2. Шураг өдөөгч болон компрессор: арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) ажлын цаг.
- 3.2.5. **Систем**
- 3.2.5.1. Сэндвийкийн шинэ Тоног Төхөөрөмжид тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг болгон суурилуулсан гал унтраах автоматжуулсан системд уг шинэ Тоног Төхөөрөмжийн баталгааны нөхцөл үйлчилнэ;
- 3.2.5.2. Сэндвийкийн Тоног Төхөөрөмжид нэмэлтээр тавьсан автоматжуулалтын систем: арван хоёр (12) сар;
- 3.2.5.3. Автоматжуулалтын систем ба талбайн бүрэлдэхүүн хэсгүүдийн техник хангамж: арван хоёр (12) сар;
- 3.2.5.4. Автоматжуулалтын систем ба талбайн бүрэлдэхүүн хэсгүүдийн техник хангамж өргөтгөл болон шинэчлэлт, гэхдээ техникийн автоматжуулалт болон сэлбэг хэрэгслийг оруулахгүй: арван хоёр (12) сар; мөн
- 3.2.5.5. Заалт 3.2.5.1-т дурдсан гал унтраах системээс өөр Гал унтраах систем: арван хоёр (12) сар.
- 3.2.6. **Сэндвийкийн Сэлбэг Хэрэгсэл**
- 3.2.6.1. Ерөнхий сэлбэг хэрэгсэл: гурван (3) сар эсхүл суурилуулсан өдрөөс эхлэн таван зуун (500) ажлын цаг, дээд тал нь Хүргэлтээс хойш зургаан (6) сар;
- 3.2.6.2. Гидравлик чулуулгийн өрөм: өмнө нь хэрэглэж байсан өрмийн машин дээр суурилуулсан гидравлик чулуулгийн өрөм: зургаан (6) сар эсхүл таван зуун (500) цохилтот цаг, мөн
- 3.2.6.3. Сэндвийкийн БГЦМ-н батареины модуль, Сэндвийкийн БГЦМ-н батареины багц: арван хоёр (12) сар.
- 3.2.7. **Сэндвийкийн Чулуулгийн Багаж**
- 3.2.7.1. Өрөмдлөгийн хэрэглээний бүтээгдэхүүн: гурван (3) сар;
- 3.2.7.2. Огтлох багаж болон чулуулгийн боолт: гурван (3) сар;
- 3.2.7.3. Нунтаглах машин болон сэлбэг хэрэгсэл: Хүргэлтээс эхлэн зургаан (6) сар эсхүл (зөвхөн сэлбэг хэрэгсэлд) суурилуулсан өдрөөс эхлэн гурван (3) сар; мөн
- 3.2.7.4. Сэндвик нь бусад чулуулгийн багажид хариуцлага хүлээхгүй бөгөөд баталгаа өгөөгүй.
- 3.2.8. **Газрын Үйлчилгээ**
- 3.2.8.1. Газарын Үйлчилгээ Үзүүлэх Тоног Төхөөрөмж: АТ – Автоматжуулалтын Нэгж (Иж Бүрдэл): арван хоёр (12) сар; мөн АТ – Шахагч Нэгж: хоёр мянга таван зуун (2500) шахах цикл;
- 3.2.8.2. Газарын Үйлчилгээний хэрэглээний бүтээгдэхүүн: Техникийн Датаны Хуудасны (ТДХ) дагуу; мөн
- 3.2.8.3. Газарын Үйлчилгээний химийн бодис: Материалын Аюулгүй Байдлын Датаны Хуудасны (МАБДХ) дагуух хадгалах хугацаа.
- 3.2.9. **Сэндвийкийн Хэрэглээний Бүтээгдэхүүн**
- 3.2.9.1. Газартай Харьцах Багаж (үүнд Shark-н бүтээгдэхүүн орно): гурван (3) сар; мөн
- 3.2.9.2. Нунтаглах аяга болон нунтаглах дугуй: гурван (3) сар.
- 3.3. **Сонголтоор авч болох Нэмэлт Баталгаа.** Худалдан авагчид тусдаа баримт бичгийн дагуу Нэмэлт Баталгаа худалдан авах боломжийг Сэндвик санал болгож магад. Аливаа Нэмэлт Баталгаа нь тухайн Нэмэлт Баталгааны баримт бичигт заасан нөхцөл болзлын дагуу үйлчилнэ.
4. **Хариуцлагаас чөлөөлөх талаарх нөхцөл**
- 4.1. Хуулиар зөвшөөрсөн хамгийн дээд хэмжээгээр:
- 4.1.1. Сэндвийкийн Бараатай холбоотойгоор хууль, тогтоомжид заасан бүх нөхцөл, болзол, баталгаа, амлалт, үүрэг, гэм хор арилгах үүргийг энэ Баталгаанаас хасаж байна;
- 4.1.2. Сэндвик нь анхны эцсийн хэрэглэгч болох Худалдан авагчаас бусад аливаа талын өмнө ямар ч хариуцлага хүлээхгүй.
- 4.2. Сэндвик дараах зүйлсэд баталгаа өгөхгүй бөгөөд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй:
- 4.2.1. Сэндвийкийн Барааны жам ёсны элэгдэл хорогдол, хэвийн засвар үйлчилгээ болон солих үйлчилгээ, тухайлбал, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, моторын тохируулга, тохируулга болон шалгалт, мөн эдгээрээс үүдэн гарсан гэмтэл;
- 4.2.2. Элэгдлийн бүх эд анги болон хэрэглээний бүтээгдэхүүн (Сэндвийкийн Хэрэглээний Бүтээгдэхүүнээс бусад) тухайлбал, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, лац, шүүлтүүр, хоолой, жийргэвч; v-бүс, дугуй, холбох хэрэгсэл, эрэг, боолт, угагч, чулуулгийн өрмийн холбох хэрэгсэл, патрон, диафрагм, түүгч, туузан дамжуулагчийн гинж ба араа, гал хамгаалагч, шүршигч цорго, ролик, чиргүүл кабель, резин тууз, хацарт бутлуур, шүд болон хутга, түлш, хөргөлтийн бодис, тос болон тосолгооны материал, болон шингээгч (шок шингээгч, зөөлөвчилсөн шингээгч) мөн тавцан бутлуур; мөн нунтаглах аяганы хэрэгсэл;
- 4.2.3. Худалдан авагч нь Сэндвийкийн Тоног Төхөөрөмжийг зөв зохистой ажиллуулаагүй эсхүл хэрэглээгүйгээс үүдсэн гэмтэл, эсхүл Сэндвийкийн хадгалалт, ашиглалт болон арчилгааны заавар, гарын авлагыг дагаж мөрдөөгүйгээс учирсан гэмтэл, эсхүл хэт ачаалалтай ажиллуулснаас эсхүл үйлчилгээ, хадгалалт, ашиглалт болон арчилгааны заавар, гарын авлагыг зохих ёсоор анхаараагүйгээс учирсан ослоос үүдсэн эсхүл ажиллах ёстой хүчин чадлаас хэтрүүлэн ажиллуулсан эсхүл эрчим хүчний оролтыг хэтрүүлсэн эсхүл зөв зохистой хэмжээнд хүргээгүйгээс болж учирсан гэмтэл;
- 4.2.4. Худалдан авагчийн хайхрамжгүй байдлаас болж учирсан гэмтэл эсхүл Худалдан авагч Сэндвийкийн хадгалалт, ашиглалт, арчилгааны заавар, гарын авлага, хэрэв байгаа бол мэдээллийн товхимолд заасны дагуу Сэндвийкийн Барааг зөв зохистой хадгалаагүй, арчлаагүй эсхүл угсраагүйгээс болж учирсан гэмтэл;
- 4.2.5. Дараах үйл ажиллагааны нөхцөлөөс учирсан гэмтэл, тухайлбал, гэхдээ үүгээр хязгаарлахагүй, гүн ба/эсхүл хүчтэй ус, муу зам, тоос шороо, муу агааржуулалт, хэт их халалт зэргээс болоод үйлдвэрлэлийн стандартын дагуу бүтээж, үйлдвэрлэсэн эд анги нь хугацаанаасаа өмнө эвдэрч гэмтэх;
- 4.2.6. Дараах зүйлсээс үүдэн гарсан аливаа гэмтэл эсхүл доголдол, (i) ханган нийлүүлсэн материал, эсхүл (ii) Худалдан авагчийн өгсөн, тодорхойлсон эсхүл тусгайлан заасан загвар, эсхүл (iii) Худалдан авагчийн үйлдэл эсхүл тусгай заалтаас үүдэн гарсан өөр бусад гэмтэл, доголдол;
- 4.2.7. Худалдан авагчийн эсхүл түүний төлөөлөгчийн Сэндвикэд өгсөн, түүнийг нь Сэндвик ашигласан, дутуу, алдаатай шалгуур үзүүлэлт, программын дата эсхүл өөр бусад мэдээллээс үүдэн гарсан аливаа доголдол, гэмтэл;
- 4.2.8. Сэндвийкийн Сэлбэг Хэрэгсэлд орохгүй сэлбэг хэрэгслээс, эсхүл гуравдагч этгээдийн технологи эсхүл гуравдагч этгээдийн харилцаанаас үүдэн гарсан аливаа гэмтэл;
- 4.2.9. Заалт 8.3-н дагуу, Сэндвийкийн Сэлбэг Хэрэгсэл эсхүл Сэндвийкийн Хэрэглээний бараанаас өөр сэлбэг хэрэгсэл эсхүл хэрэглээний барааг суулгасан, угсарсан эсхүл нэгтгэсэн үед Сэндвийкийн Бараанд учирсан доголдол;
- 4.2.10. Гуравдагч этгээдийн нийлүүлсэн аливаа сэлбэг хэрэгсэл эсхүл хэрэглээний бараанд Сэндвийкийн Барааны учруулсан гэмтэл;
- 4.2.11. Сэндвийкийн Сэлбэг Хэрэгслийг тэдгээрийн ЖТТҮ-н зөвлөсөн программын дагуу ашиглаагүй эсхүл суурилуулаагүй;
- 4.2.12. Аливаа зардал, тухайлбал ажлын, орон байрны, хоол, унааны болон тээврийн болон түүнтэй адил зардлууд;
- 4.2.13. Сэндвик бичгээр, тусгайлан өөрөөр заагаагүй бол, Сэндвийкийн хийх эсхүл бэлэн болгосон бүтээгдэхүүний сайжруулалт, шинэчлэл;
- 4.2.14. Сэндвийкийн Сэлбэг хэрэгсэл эсхүл Сэндвийкийн Тоног Төхөөрөмжийн эд ангийг бага хэмжээний арга хэмжээ аван засаж янзлах боломжтой бол, тухайлбал, гэхдээ үүгээр

- хязгаарлагдахгүй, лацыг солих, чангалалт эсхүл тохируула хийх;
- 4.2.15. Сэндвикийн БГЦМ бүтээгдэхүүний хувьд: Сэндвикийн БГЦМ-н хадгалалт, ашиглалт, арчилгааны заавар, гарын авлагын дагуу батареины модуль болон батареины багцыг хадгалаагүй эсхүл арчлаагүй;
- 4.2.16. Шаардлагатай засвар үйлчилгээг Сэндвик эсхүл Сэндвикээс зөвшөөрөл авсан үйлчилгээ үзүүлэгч түншээс өөр этгээдийн хийсэн суурилуулалт, нөхцөл байдлын шалгалт, техникийн туслалцаа болон үйлчилгээнээс үүдэн гарсан доголдол, гэмтэл, мөн гал унтраах системийн хувьд Сэндвикээс зөвшөөрөл аваагүй эсхүл Сэндвикээс итгэмжлэл аваагүй техникчийн суурилуулсан эсхүл ашиглалтад оруулснаас үүдэн гарсан доголдол, гэмтэл.
- 5. Баталгааны Бүртгэл**
- 5.1. Сэндвикийн Тоног Төхөөрөмжийг Ашиглалтад оруулахад Худалдан авагч Сэндвикийн Баталгааны Бүртгэлийн Маягт болон ашиглалт эхлүүлэх баримт бичгийг бөглөж, гарын үсэг зуран Ашиглалтад оруулсан өдрөөс хойш хуанлийн арван дөрвөн (14) өдрийн дотор Сэндвикийн төлөөлөгчид хүргүүлнэ. Холбогдох Сэндвикийн Бараанд, Сэндвикийн Баталгааны бүртгэлийн маягыг Сэндвикийн Баталгааны бүртгэл хийх тусгай дижитал платформоор дамжуулан цахимаар хийнэ.
- 5.2. Аливаа Баталгааны дагуу гаргасан нэхэмжлэлийг Сэндвик хүлээн авч, хянан үзэхээс өмнө Сэндвикийн Баталгааны Бүртгэлийн Маягыг бөглөж, гарын үсэг зуран Сэндвикэд хүргүүлсэн эсхүл, дижитал платформ дээр бүртгүүлсэн байх ёстой.
- 5.3. Моторын Баталгааны бүртгэлийг Ашиглалтад оруулах үед орон нутгийн моторын ЖТТҮ-н төлөөлөгчийн хамт тусад нь бөглөх ёстой.
- 6. Баталгааны дагуух Нэхэмжлэлийн Журам**
- 6.1. **Худалдан авагчийн Нэхэмжлэл.** Худалдан авагч энэхүү Баталгаанд заасан эрхээ хэрэгжүүлэхийн тулд, Сэндвик эсхүл Сэндвикийн Борлуулагчид аливаа доголдол илэрмэгц хугацаа алдалгүй бичгээр мэдэгдэж мөн Сэндвикэд уг доголдлыг шалгаж, засварлах боломжийг Худалдан авагч түүнд олгох ёстой.
- Хэрэв доголдол нь хохирол учруулж болзошгүй бол, Худалдан авагч нэн даруй Сэндвик эсхүл Сэндвикийн Борлуулагчид бичгээр мэдэгдэх ёстой. Худалдан авагч ийнхүү мэдэгдээгүйгээс үүдэн Сэндвикийн Бараанд учирч болох хохирлын эрсдэлийг хариуцна. Худалдан авагч хохирлыг бууруулах боломжит арга хэмжээг авах ёстой ба үүнтэй холбоотой Сэндвикийн зааврыг дагаж мөрдөнө.
- 6.2. **Баталгааны Өргөдлийн маягт.** Баталгааны дагуух нэхэмжлэлийг Сэндвикийн Баталгааны Өргөдлийн Маягыг ашиглан бичгээр гаргана. Худалдан авагч сэжиглэж буй доголдлыг илрүүлсэн эсхүл илрүүлэх ёстой байсан өдрөөс эхлэн хуанлийн арван дөрвөн (14) өдрийн дотор хуудсыг бүрэн бөглөж Сэндвикийн төлөөлөгчид хүргүүлнэ. Энэ хугацаанаас хойш гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахгүй ба Худалдан авагч энэ Баталгааны дагуу доголдлыг арилгуулах эрхээ алдана. Сэжиглэгдэж буй доголдол бүрийг Сэндвикийн Баталгааны Өргөдлийн маягтад тусад нь дэлгэрэнгүй бичих ёстой.
- 6.3. **Нотлох баримт.** Сэндвикийн Баталгааны Өргөдлийн маягыг доголдол, эвдрэлийн тодорхой дижитал гэрэл зураг болон баримтжуулсан үйлчилгээний түүхийн (үүнд цуглуулсан дата болон/эсхүл тосны дээжийн сорил болон/эсхүл тосны даралтын тохиргоо, хэрэв хамааралтай бол) хамт явуулах ёстой. Сэндвик нэмэлт мэдээлэл болон/эсхүл үйл ажиллагааны дата, хэрэв хамааралтай бол хүсэж магад. Энэ тохиолдолд, Худалдан авагч хариу өгөх ёстой ба хүссэн мэдээллийг Сэндвикийн хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хуанлийн таван (5) өдрийн дотор явуулах ёстой. Сэндвикийн Баталгааны Өргөдлийн Маягт нь чулуулгийн өрөмдлөгийн эвдрэлтэй холбоотой бол Сэндвикийн Дрифтерын Алдааны Тайланг хавсаргах ёстой. Хэрэв нэхэмжлэл нь компрессорын эвдрэлтэй холбоотой бол, Сэндвикийн Баталгааны Өргөдлийн Маягт гишгүүр өрмийн эвдрэлийн талаар бол Компрессорын Алдааны Тайланг хавсаргах ёстой.
- 6.4. **Мотор.** Мотортой холбоотой нэхэмжлэлийг орон нутгийн ЖТТҮ-н моторын төлөөлөгчтэй хамтарч хянана. Худалдан авагч нэхэмжлэлийн мэдэгдлийн хуулбарыг Сэндвикэд өгөх ёстой.
- 6.5. **Худалдан авсан гэдгээ батлах.** Бүх Баталгааны дагуух нэхэмжлэл нь худалдан авалт хийснийг батлах баримтуудыг хавсаргана, тухайлбал:
- 6.5.1. Худалдан авалтын захиалгын хуулбар эсхүл худалдан авалтын захиалгын дугаар;
- 6.5.2. Нэхэмжлэлийн хуулбар эсхүл нэхэмжлэлийн дугаар; эсхүл
- 6.5.3. Ажлын төлбөрийн тайлан.
- 6.6. **Буцаалт хийх дүрэм.** Худалдан авагч сэжиглэгдэж буй доголдолтой Сэндвикийн Бараа, уг Барааны холбогдох эд анги, хэсгийг Сэндвикийн шалгалтад зориулж нэхэмжлэл хангагдсанаас хойш хуанлийн ерэн (90) өдөр хадгалах ёстой ба сэжиглэгдэж буй доголдолтой эд анги, хэсгийг Сэндвикийн зардлаар түүний хүсэлт, зааврын дагуу, хүргэх ёстой хаяг руу нь илгээх ёстой. Сэндвикийн Бараа эсхүл Сэндвикийн Барааны аливаа эд ангийг Сэндвикэд түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр буцааж болохгүй. Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн бол, Баталгааны Нэхэмжлэлийн журмын дараа, доголдолтой буцаагдсан эд анги, хэсгийн өмчлөх эрх Сэндвикэд шилжинэ.
- 6.7. **Буцаалт хийх Хаяг.** Сэндвикийн Барааг 6.6-р заалтын дагуу орон нутгийн Сэндвикийн төлөөлөгчид буцаана.
- 6.8. **Давж заалдах.** Баталгаатай холбоотой нэхэмжлэлийн шийдвэрийг давж заалдах хүсэлтийг шийдвэр гарсан өдрөөс эхлэн хуанлийн арван дөрвөн (14) өдрийн дотор Сэндвикийн төлөөлөгчид бичгээр гарган гаргах ёстой, ба энэ хугацаа дууссаны дараа шийдвэр эцсийнх болно.
- 7. Баталгааны дагуу хүлээх Сэндвикийн үүрэг**
- 7.1. Сэндвикийн Баталгааны Өргөдлийн Хуудсыг аваад, Сэндвик нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрвөл, энэхүү Баталгааны дагуух Сэндвикийн үүрэг нь дараах үүргээр, Сэндвикийн сонголтын дагуу, хязгаарлагдана:
- 7.1.1. Нөөцөө нөхөх захиалгын үнээр Сэндвикийн Барааны төлбөрийн буцаалт хийх;
- 7.1.2. Сэндвикийн Барааг засварлах; эсхүл
- 7.1.3. Сэндвикийн Барааг үнэ төлбөргүй, Сэндвикийн төлөөлөгчийн бизнесийн хаяг дээр DDP (хүргэсэн, хураамж төлсөн, Инкотермс 2020) нөхцөлөөр сольж өгөх.
- 7.2. **Сольж өгсөн сэлбэг хэрэгслийн баталгаа.** Сэндвикийн Тоног Төхөөрөмж эсхүл Сэндвикийн Сэлбэг Хэрэгслийн доголдлыг засварласан бол, тухайн сольсон эсхүл засварласан эд ангийн Баталгаа нь нийлүүлсэн Сэндвикийн Тоног Төхөөрөмж эсхүл Сэндвикийн Сэлбэг Хэрэгслийн анхны Баталгаатай нэгэн зэрэг хугацаанд дуусгавар болно.
- 7.3. **Сольж өгсөн Сэндвикийн Чулуулгийн Багаж болон Сэндвикийн Хэрэглээний бүтээгдэхүүний Баталгаа.** Сэндвик нь Сэндвикийн Чулуулгийн Багаж болон Сэндвикийн Хэрэглээний бүтээгдэхүүнийг сольж нийлүүлсэн бол тэдгээр нь шинэ Сэндвикийн Чулуулгийн Багаж болон Сэндвикийн Хэрэглээний бүтээгдэхүүнд өгдөг Баталгаатай сольж өгсөн өдрөөс эхлэн адил баталгаатай байна.
- 8. Хязгаарлалт**
- 8.1. **Хариуцлагын ерөнхий хязгаарлалт.** Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд, аливаа Гэрээ болон бусад байдлаар үүссэн, түүнтэй холбоотой нэг эсхүл нэлээд хэдэн нэхэмжлэлийг нэгтгэсэн байна уу Сэндвикийн хариуцлага нь хариуцлага үүсгээд байгаа тухайн Сэндвикийн Барааг худалдан авах Гэрээний дагуух худалдан авах үнийн дүнгээс хэтрэхгүй.
- 8.2. **Үнэлгээний босго.** Баталгааны дагуух нэхэмжлэл нь тавин евро (EUR 50) болон түүнээс дээш эсхүл үүнтэй тэнцэх өөр валютын дүнтэй байх ёстой.
- 8.3. **Зөвхөн Сэндвикийн Бараа.** Энэ Баталгаа нь Сэндвикийн Бараанд л хамааралтай. Сэндвикийн биш бараанд Сэндвик ямар ч хариуцлага хүлээхгүй. Сэндвикийн биш барааг хэрэглээд тэдгээр нь Сэндвикийн Барааг гэмтээсэн эсхүл гэмтэхэд нөлөөлсөн бол энэ Баталгаа хүчингүй болно эсхүл энэ Баталгаанд нөлөөлнө. Заалт 4-т заасан нөхцөл байдлаас гадна дараах тохиолдолд ямар ч нэхэмжлэлийг хүлээн авахгүй:
- 8.3.1. Сэндвикийн Тоног Төхөөрөмжид Сэндвикийн Сэлбэг Хэрэгслийг хэрэглээгүй тохиолдол; эсхүл
- 8.3.2. Сэндвикийн Сэлбэг Хэрэгсэл, Сэндвикийн Чулуулгийн Багаж эсхүл Сэндвикийн Хэрэглээний бүтээгдэхүүнийг салган авч Сэндвикийн Тоног Төхөөрөмжөөс өөр бүтээгдэхүүнд

ашигласан мөн тэдгээрийг ЖТТҮ-н зөвлөсөн программын дагуу ашиглаагүй, суурилуулаагүй.

- 8.4. **Баталгааны хугацаа зогсохгүй.** Энэ Баталгааны хугацаа ашиглаагүй, үе үе ашигласан болон бусад ямар нэгэн шалтгаанаар зогсохгүй.
- 8.5. **Баталгааг шилжүүлэхгүй.** Хуулиар зөвшөөрсөн хэмжээнд, хэрэв Худалдан авагч гуравдагч этгээдэд энэхүү Баталгааны дагуух эрхээ шууд болон шууд бусаар шилжүүлэх, өгөх өөр бусад хэлбэрээр өгөхийг оролдсон тохиолдолд энэ бүх баталгаа нь нэн даруй цуцлагдана гэдгийг Худалдан авагч хүлээн зөвшөөрч байна. Худалдан авагчид Сэндвик урьдчилж бичгээр зөвшөөрөл өгөөгүй л бол, Сэндвикийн өгсөн баталгааг гуравдагч этгээдэд өгөх эсхүл шилжүүлэх гэсэн Худалдан авагчийн аливаа оролдлого нь хүчин төгөлдөр бус байна. Сэндвикээс зөвшөөрөл өгөхөөс өмнө Сэндвикийн Тоног Төхөөрөмжид үзлэг хийх болон тусдаа Сэндвикийн Баталгааны Бүртгэлийн Маягтыг ямагт өгсөн байх ёстой. Ямар ч тохиолдолд зөвшөөрсөн шилжүүлэг нь Сэндвикийн Тоног Төхөөрөмжид өгсөн анхны Баталгааны хугацааг сунгахгүй.
- 8.6. **Өгч буй бүх Баталгаа.** Энэ Баталгаа нь шууд, шууд бус, хуулийн дагуух өөр бусад бүх баталгаа, болзлын оронд өгч байгаа баталгаа. Аливаа Сэндвикийн Барааны чанар, үүрэг гүйцэтгэл эсхүл ямар нэгэн доголдолгүй гэж Сэндвик шууд болон шууд бусаар баталж, амлаж, баталгаа (дагалдсан, өмнөх болон өөр бусад байдлаар) өгөөгүй. Ялангуяа, худалдаалах, зорилгодоо нийцэх, ямар нэгэн тодорхой үр дүн, чанарт хүрэх чадварын талаар бодитоор эсхүл шууд бусаар баталгаа өгөөгүй. Сэндвик бичгээр тодорхой өгөөгүй л бол өөр ямар ч баталгааг шууд болон шууд бусаар өгөөгүй. Энэхүү Баталгаа нь Сэндвик болон Худалдан авагч хоёрын хоорондын баталгааны бүх болзол, нөхцөлийг агуулсан болно.
- 8.7. **Шууд бус хохирол байхгүй.** Ийм хохирол хэрхэн үүснээс үл хамааран (үүнд гэрээ эсхүл баталгаа зөрчсөнтэй холбоотой нэхэмжлэл, гэм хор (үүнд хайхрамжгүй хандах орно), бүтээгдэхүүний хариуцлага, нөхөн төлбөр, хариуцлага хуваалцах, шууд хариуцлага эсхүл өөр бусад эрх зүйн онол зэрэг орно), хуулиар зөвшөөрсөн хүрээнд, Сэндвик шууд бус, үр дагаврын, онцгой, шийтгэлийн шинжтэй хохирол мөн бодит эсхүл хүлээгдэж байсан ашиг, орлогын алдагдал; бизнес эсхүл үйлчлүүлэгчээ алдах; хадгаламжийн эсхүл хүлээгдэж буй хадгаламжийн алдагдал; гэрээ алдах эсхүл аливаа гэрээний, үүнд Гэрээ орно, дагуу боломжоо алдах; өөр бусад боломж алдах, татгалзсан хариу авах; зах зээлд нэвтрэх боломжоо алдах; Сэндвикийн Барааг орлуулах эсхүл өөр нийлүүлэгч олоход зарцуулсан зардал; үйлдвэрлэлийн алдагдал эсхүл тасалдлаас үүдсэн алдагдал (үүнд дуусаагүй байсан ажлыг гүйцээхэд гарсан зардал орно); Гэрээтэй эсхүл Сэндвикийн Бараатай холбоотой Худалдан авагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнээс үүдсэн алдагдал, үүнд худалдах, худалдан авах гэрээ, оф-тэйк гэрээ; ашиглах боломж алдах; хөрөнгө, тоног төхөөрөмж алдах; үйл ажиллагаа явуулаагүй, хааснаас болоод үүдсэн алдагдал; капитал болон үйл ажиллагааны зардлын өсөлт; нэр хүндээ алдах; мэдээлэл болон дата алдах; санхүүжилтийн зардлын өсөлт эсхүл шинээр санхүүжилт авахад гарах зардал; менежер эсхүл ажилчдын цагийн зардлын хохирол зэрэгт хариуцлага хүлээхгүй гэдгээ тодорхой мэдэгдэж байна. Худалдан авагч Сэндвик, Сэндвик Группийн гишүүд, тэдгээрийн хамааралтай этгээд, гэрээлэгч, туслах гэрээлэгч, зөвлөх, ажилтан, төлөөлөгч, Сэндвикийн Борлуулагч нарын эсрэг 8.7-р заалтад заасан аль ч төрлийн гарз хохиролтой холбоотойгоор шууд бус гарз хохирлын нэхэмжлэл гаргахаасаа татгалзаж, тэдгээрт учирч болох үүнтэй холбоотой хохирлыг нөхөн төлж, гэм хоргүй болгоно.
- 8.8. Энэхүү Баталгаанд дурдсан Сэндвикийн хариуцлагын бүх хязгаарлалтууд нь Сэндвикийн баталгаа нь үндсэн зорилгодоо хүрээгүй эсхүл хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй байсан ч үйлчилнэ.

Анхаарал хандуулах чухал зүйл: Сэндвикийн Борлуулагч ямар нэгэн байдлаар энэ Баталгааны нөхцөл эсхүл хязгаарлалтыг өөрчлөх болон аливаа мэдэгдэл, амлалт, зөвшөөрөл эсхүл тайлбар өгөх эрхгүй. Сэндвикийн өгсөн цорын ганц баталгаа нь энэхүү баримтад дурдсан баталгаа юм.

СЭНДВИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
Өрөмдлөгийн Машин	
Эргэлтэд мөн өндөр даралтат доошоо нүхлэх (DTH-down-the-hole) өрөм (Агаарын Төгсгөл, Эргэлтийн Толгой, Поршений насос болон Мотор мөн Тэжээх болон Домкрат Цилиндрээс бусад)	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг
Агаарын Төгсгөл	Хорин дөрвөн (24) сар мөн цагийн хязгааргүй эргэлтэд өрөмдлөг
Эргэлтийн Толгой	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй эргэлтэд өрөмдлөг
Поршений насос болон Мотор	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй эргэлтэд өрөмдлөг
Тэжээх болон Домкрат Цилиндр	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй эргэлтэд өрөмдлөг
Гадаргуун топ алх өрөмдлөгийн машин (Агаарын Төгсгөл, Поршений насос болон Мотор мөн Гидравлик чулуулгийн өрмөөс бусад)	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг
Агаарын Төгсгөл	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй гадаргуун топ алх өрөмдлөгийн машин
Поршений насос болон Мотор	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй гадаргуун топ алх өрөмдлөгийн машин
Гидравлик чулуулгийн өрөм	арван хоёр (12) сар эсхүл гадаргуун топ алх өрөмдлөгийн машины нэг мянган (1000) цохилтот цаг
Газар доорх топ алх өрөмдлөгийн машин	арван хоёр (12) сар
Гидравлик чулуулгийн өрөм	арван хоёр (12) сар эсхүл нэг мянган (1000) цохилтот цаг
Газар доорх нүхэн дэх (ITH-in the hole) өрөмдлөгийн машин (харилцан өдөөгчөөс бусад)	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган гидравлик эрчим хүчний багц цаг
Харилцан өдөөгч	нэг мянган (1000) ажлын цаг
Доошоо нүхлэх (DTH-Down the Hole) алх (шинэ өрөмдлөгийн машинтай хамт зарагдсан бол)	гурван (3) сар
Гадаргуун доошоо нүхлэх (DTH-Down the Hole) Өрөм (Агаарын Төгсгөл, Эргэлтийн Толгой, мөн Поршений насос болон Мотороос бусад)	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг
Агаарын Төгсгөл	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй гадаргуун доошоо нүхлэх (DTH-down the hole) өрөмдлөг
Эргэлтийн Толгой	арван хоёр (12) сар эсхүл гадаргуун доошоо нүхлэх (DTH-down the hole) өрмийн хоёр мянган (2000) моторын цаг
Поршений насос болон Мотор	арван хоёр (12) сар мөн цагийн хязгааргүй гадаргуун доошоо нүхлэх (DTH-down the hole) өрөмдлөг
Өргүүрт цооноглох өрөмдлөгийн машин	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) гидравлик эрчим хүчний багц цаг, үүнд дараах ороогүй: харилцан өдөөгч: нэг мянган (1000) ажлын цаг

СЭНДВИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
Ачих болон Зөөх	
Ачигч болон ачааны машин	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) ажлын цаг
Сэндвийн БГЦМ-н батарей	арван хоёр (12) сар
Сэндвийн БГЦМ-н батарей цэнэглэх болон хөргөх нэгжүүд	арван хоёр (12) сар
Механик Огтлогч	
Механик Огтлогч	арван хоёр (12) сар эсхүл дөрвөн мянган (4000) гидравлик моторын цаг, үүнд доорх ороогүй: өрмийн толгой: зургаан (6) сар
Резин дугуйтай тээврийн хэрэгсэл (RTV-rubber-tired vehicle)	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) моторын цаг
Хурдан салгах системийн хэрэгсэл	зургаан (6) сар
Өдөөгч болон Компрессор	
Харилцан өдөөгч	арван хоёр (12) сар эсхүл нэг мянган (1000) ажлын цаг
Шураг өдөөгч болон компрессор	арван хоёр (12) сар эсхүл хоёр мянган (2000) ажлын цаг
Систем	
Сэндвийн шинэ Тоног Төхөөрөмжид тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг болгон суурилуулсан гал унтраах автоматжуулсан систем	Суурилуулсан шинэ Тоног Төхөөрөмжийн баталгааны нөхцөлөөр зохицуулагдана
Сэндвийн Тоног Төхөөрөмжид нэмэлтээр тавьсан автоматжуулалтын систем	арван хоёр (12) сар
Автоматжуулалтын систем ба талбайн бүрэлдэхүүн хэсгүүдийн техник хангамж	арван хоёр (12) сар
Автоматжуулалтын систем ба талбайн бүрэлдэхүүн хэсгүүдийн техник хангамж өргөтгөл болон шинэчлэлт, гэхдээ техникийн автоматжуулалт болон сэлбэг хэрэгслийг оруулахгүй	арван хоёр (12) сар
Гал унтраах систем	арван хоёр (12) сар

СЭНДВИКИЙН СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
Ерөнхий Сэлбэг Хэрэгсэл	Гурван (3) эсхүл суурилуулсан өдрөөс эхлэн (500) ажлын цаг, дээд тал нь Хүргэлтээс эхлэн зургаан (6) сар
Өмнө нь хэрэглэж байсан өрөмдлөгийн машин дээр суурилуулсан Гидравлик Чулуулгийн Өрөм	Хүргэлтээс эхлэн зургаан (6) сар эсхүл өмнө нь хэрэглэж байсан өрмийн машин дээр суурилуулсан өдрөөс эхлэн таван зуун (500) цохилтот цаг.
Хэрэглэж байсан Сэндвийн Тоног Төхөөрөмж дээр	Огтлогчийн Хурдны хайрцаг: есөн (9) сар эсхүл суурилуулсан өдрөөс эхлэн хоёр мянган (2000) цэвэр огтлох цаг,

суурилуулсан Механик огтлогчийн үндсэн эд анги	дээд тал нь Хүргэлтээс эхлэн арван хоёр (12) сар; хэрэв Худалдан авагч өөрөө сольсон бол түүнийг нь Сэндвик хүлээн зөвшөөрөх процесс (дигиталаар шалгах протокол) явагдах ёстой. Огтлогч E-Мотор (>200kW): есөн (9) сар эсхүл суурилуулсан өдрөөс эхлэн хоёр мянган (2000) цэвэр огтлох цаг, дээд тал нь Хүргэлтээс эхлэн арван хоёр (12) сар; хэрэв Худалдан авагч өөрөө сольсон бол түүнийг нь Сэндвик хүлээн зөвшөөрөх процесс (дигиталаар шалгах протокол) явагдах ёстой. Өрмийн Толгой: суурилуулсан өдрөөс эхлэн зургаан (6) сар, дээд тал нь Хүргэлтээс эхлэн есөн (9) сар
Нунтаглах машины сэлбэг хэрэгсэл	Хүргэлтээс эхлэн зургаан (6) сар эсхүл суурилуулсан өдрөөс эхлэн гурван (3) сар
Сэндвийн БГЦМ-н батарейны модуль	арван хоёр (12) сар
Сэндвийн БГЦМ-н батарейны багц	арван хоёр (12) сар

СЭНДВИКИЙН ЧУЛУУЛГИЙН БАГАЖ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
Өрөмдлөгийн хэрэглээний бараа	гурван (3) сар
Огтлох багаж болон чулуулгийн боолт	гурван (3) сар
Нунтаглах машин	зургаан (6) сар

ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
АТ – Автоматжуулалтын Нэгж (Иж Бүрдэл)	арван хоёр (12) сар
АТ – Шахагч Нэгж	Хоёр мянга таван зуун (2500) шахах цикл
Газрын Үйлчилгээний хэрэглээний бүтээгдэхүүн	Техникийн Дата Хуудасны (ТДХ) дагуу
Газарын Үйлчилгээний химийн бодис	Материалын Аюулгүй Байдлын Дата Хуудасны (МАБДХ) дагуух хадгалах хугацаа

СЭНДВИКИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ МАТЕРИАЛ	
Бүтээгдэхүүн	Баталгааны Нөхцөл
Газартай харьцах Багаж	гурван (3) сар
Цохилтот роторын элэгдлийн хэсгүүд	гурван (3) сар
Нунтаглах аяга, нунтаглах дугуй	гурван (3) сар

SANDVIK MINING AND ROCK SOLUTIONS Standard Warranty

(Effective for Sandvik Equipment, Spare Parts, Rock Tools and Consumables sold after April 15, 2024)

9. Definitions:

